



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

06.15 - 06.19



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөж өмнөх долоо хоногийн алдагдлаа нөхлөө. Технологийн компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq Composite индекс хамгийн их өсөлт үзүүлсэн ба 06 сарын 10-ны өдрийн түүхэн дээд хэмжээндээ дөхөж очсон байна. Эрчим хүчний салбарын компаниуд хамгийн их өсөлтийг үзүүлсэн ба энэхүү өсөлт нь газрын тос экспортлогч томоохон улсууд үйлдвэрлэлээ бууруулах тохиролцоо болон дэлхийн газрын тосны эрэлт эргэн сэргэх хадлагатай байгаатай холбоотой. Агаарын нислэг ахин сэргэснээс үүдэн, долоо хоногийн эхэнд Boeing компани болон нислэгийн компаниудын хувьцаа өсөлттэй хаагдлаа. Мөн эрүүл мэнд болон хангамжийн нөөцийн салбарууд энэ долоо хоногт өсөлттэй байсан бол үл хөдлөх хөрөнгө болон нийтийн аж ахуйн салбарууд уналттай байлаа.

Зарим мужуудад цар тахлын байдал улам хурцдаж байгаа болон Бээжин хотод дахин вирус тархсаны улмаас долоо хоногийн эхэнд хөрөнгийн зах зээлийн индексүүд уналттай байсан. Гэхдээ даваа гарагт Холбооны Нөөцийн Сангаас компанийн бонд худалдан авна гэж мэдээлснээр хөрөнгийн зах зээл эргэн сэргэж эхэлсэн байна.

Европ: Энэ долоо хоногт Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд эдийн засгийг дэмжих хөтөлбөрүүд болон томоохон эдийн засагтай улсууд эрэн нээгдэж эхэлсэнтэй холбоотой өсөлттэй хаагдлаа. Гэхдээ АНУ болон БНХАУ-д Covid-19 вирус дахин дэгдэж байгаагаа нь ойрын хугацаанд эдийн засаг эргэн сэргэх итгэлийг бууруулж энэ долоо хоногийн өсөлтийг хязгаарласан байна. Энэ долоо хоногт STOXX Europe 600 индекс 3.31%-аар, Xetra DAX индекс 3.51%-аар, CAC 40 индекс 3.23%-аар, FTSE MIB индекс 3.99%-аар, FTSE 100 индекс 2.93%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Евро бүсийн бондын зах зээлд өгөөж савлагаа ихтэй байлаа. Холбооны Нөөцийн Сан компанийн бондыг худалдан авах шийдвэр гаргаснаар эрсдэл байгаатай хөрөнгийн эрэлтийг бууруулан бондын өгөөжийг өсгөсөн байна.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт бага өсөлттэй байлаа. Nikkei 225 индекс 173.31 пункт буюу 0.78% -аар өсөж 22,478.79 нэгж хүрч хаагдлаа. TOPIX Small индекс 1.6%-аар өсөж Nikkei болон large-cap TOPIX индексийг өсөлтөөрөө тэргүүлсэн байна.

Япон улсын сангийн яамнаас сөргөөр тархалт дэлхийн эрэлтэд сөрөгөөр нөлөөлж Япон улсын нийт экспорт өмнөх жилийн 05-р сартай харьцуулахад 28.3%-аар буурсан бол тээврийн хэрэгслийн экспорт 60%-аар буурсан байна гэж мэдэгдлээ.

БНХАУ: 06-р сарын 13-ны Бямба гарагт БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо COVID-19 вирусийн шинэ тохиолдол бүртгэгдэж, халдварын 2 дахь давлагаа явагдах эрсдэлтэй байгаа ч үүнээс үл хамааран БНХАУ-ын зах зээлийн үнэлгээ ихтэй компаниудаас бүрдэх CSI 300 индекс энэ долоо хоногт 2.4%-аар өссөн бол Shanghai Composite индекс 1.6%-аар өссөн байна. Цар тахлын шинэ тохиолдол бүртгэгдсэний улмаас хөл хориогоо цуцалж эхлээд байсан Бээжин хот шилжих хөдөлгөөндөө хязгаарлалт тавиад байна. Хэдийгээр вирусийн хоёрдох давлагааны аюул байсаар байгаа ч мэргэжилтнүүд БНХАУ-ыг хариу араг хэмжээ амжилттай авч чадна гэсэн хүлээлттэй байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,203.99	0.82% ▲
Dow Jones	АНУ	25,871.46	0.86% ▲
S&P 500	АНУ	3,097.74	1.86% ▲
Nasdaq	АНУ	9,946.12	3.73% ▲
S&P/TSX	Канад	15,474.20	1.43% ▲
FTSE 100	Их Британи	6,292.60	3.07% ▲
S&P/ASX 200	Австрали	5,942.60	1.62% ▲
Nikkei 225	Япон	22,478.79	0.78% ▲
Hang Seng	Хонг Конг	24,643.89	1.41% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	108.03
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	100.28
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	99.75
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.36
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.55
DBM' 2023	USD	7.250%	96.53
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	87.46

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.190	-0.01 ▼
Libor 3M	0.305	-0.02 ▼
Libor 6M	0.415	-0.02 ▼
Libor 1YR	0.576	-0.02 ▼
US 2YR Bond	0.188	0.01 ▲
US 3YR Bond	0.218	0.01 ▲
US 5YR Bond	0.327	0.02 ▲
US 10YR Bond	0.692	0.03 ▲

Валютын ханш	2020.06.19	Өөрчлөлт
USD	2,819.57	0.23% ▲
CNY	398.33	0.19% ▲
EUR	3,160.46	-0.81% ▼
RUB	40.54	0.40% ▲
KRW	2.33	-0.43% ▼
JPY	26.36	0.42% ▲
CAD	2,076.19	0.09% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,743.87	0.76% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	17.62	0.76% ▲
Зэс	USD/lb.	262.80	0.36% ▲
Нүүрс	USD/MT	54.12	0.26% ▲
WTI газрын тос	USD/bbl.	39.75	9.62% ▲
Brent газрын тос	USD/bbl.	42.19	8.93% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	1.67	-3.47% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.V	3.3%
Бодлогын хүү	2020.V	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.V	8.93%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.V	11.20%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.V	4.48%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.V	17.06%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.V	10.41%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 41 компанийн 597.6 сая төгрөгийн 4,409,090 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Улсын их дэлгүүр” /UID/ компанийн хувьцаа 28.85%-аар буюу хамгийн ихээр өсөж 800.00 төгрөг хүрч хаагдсан бол “БиДиСек” /BDS/ компанийн хувьцаа 13.81%-аар буурч 861.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 3,819 ширхэг үнэт цаас 383.5 сая төгрөгөөр арилжаалагджээ.

06-р сарын 19-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,458.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,203.99 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.82%-аар өссөн байна.



Зах зээлийн тойм		Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн		981.2
Зах зээлийн үнэлгээ		2,458,173.4
Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,203.99	0.82% ▲
MSE I индекс	7,945.65	-0.30% ▼
MSE II индекс	7,381.11	1.06% ▲
Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Ард даатгал	504,303	353,041,802
Лэндмн ББСБ	3,170,817	98,338,648
АПУ	53,228	28,926,076
Бодь Даатгал	225,212	25,592,842
Говь	89,889	17,114,103
Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Улсын их дэлгүүр	800.00	28.85% ▲
Шарын гол	1,139.00	26.56% ▲
Сор	805.00	15.00% ▲
Хар хорум пропертийс	420.00	12.90% ▲
Стандарт агрикалчер групп	38.00	11.76% ▲
Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
БиДиСек	861.00	-13.81% ▼
Нэхээсгүй эдлэл	1,900.00	-13.64% ▼
Техник импорт	7,005.00	-12.44% ▼
Авто импекс	1,300.00	-10.34% ▼
Дархан нэхий	12,000.00	-8.75% ▼
Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК		Дүн (төг)
БиДиСек		797,033,975
Бумбат-Алтай		108,996,302
Райнос инвестмент		56,081,647
Ард секюритиз		53,642,209
Мирэ Эссет Секьюритис Монгол		37,132,764
Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	546.00	581,043
Таван толгой	5,490.00	289,132
МИК холдинг	12,650.00	261,973
Инвескор ББСБ	2,498.00	179,176
Говь	194.98	152,106

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-18/07/20-A0275-15.14	2,818	282,973,970	100,370	100,460	156	15.140%
2	ZGEB-BD-18/07/20-A0275-15.14	1,001	100,550,450	100,450	100,450	156	15.140%

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТҮР БҮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БҮК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAH	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.05.31-НИЙ ДОТОР
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 06-р сарын 10-ны өдрийн 476 тоот тогтоолоор “Капитал маркет корпораци ҮЦК” ХХК-ийн үнэт цаасны зах зээлд брокер, дилер, андеррайтерын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна. Тусгай зөвшөөрөл хүчингүй болгосонтой холбоотойгоор харилцагчдыг шилжүүлэх арга хэмжээг Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Говь” /MSE: GOV/ ХК-ийн ТУЗ-ын хурлын шийдвэрээр “Гоёо” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар О. Болорбат томилогдлоо.

Монголын ноос ноолууран бүтээгдэхүүний зах зээлд томоохон байр суурийг эзэлдэг “Говь” ХК /MSE: GOV/-ийн ТУЗ-ийн хурал 2020 оны 04-р сарын 24-ны өдөр зохион байгуулагдана хэмээн тус компанийн зүгээс зарлаж байсан билээ.

Тус хурлын дүнд гарсан чухал шийдвэрүүдийн нэг нь “Гоёо” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н. Сүрэнрагчаа өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөний улмаас түүний оронд О. Болорбатыг томилон ажиллуулахаар хурлын 100% саналаар шийдвэрлэсэн байна.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /MSE:ERDN, TSE:ERD/ ХК-аас ирүүлсэн мэдээлэл.

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /MSE:ERDN, TSE: ERD/ ХК нь Баян Хөндий Алтны Төслийн тусгай зөвшөөрлийн талбайд эхлүүлсэн өрөмдлөгийн хөтөлбөрийн тухай мэдээлэл ирүүлсэн байна.

Уг өрөмдлөгийн хөтөлбөр нь хаягдал эсвэл бага агуулга бүхий овоолгын материалд ангилагдсан бүсүүдийн эрдэсжилтийг шалгах зорилготой байсан боловч алтны агуулгатай шинэ бүсийг илрүүлсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Хар хорум пропертийс” /MSE: AMT/ ХК-аас ирүүлсэн мэдээлэл.

Монголын хөрөнгийн биржийн 3-р ангилалд бүртгэлтэй “Хар Хорум пропертийс” /MSE: AMT/ ХК-ийн 100 хувь охин компани болох “Эрдэнэ рийл эстэйт” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 327 тоот тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл” авсан бөгөөд 2020 оны 06-р сарын 08-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газар бүртгүүлсэн байна.

Энэхүү тусгай зөвшөөрлийн дагуу үл хөдлөх хөрөнгийн менежмент, худалдах, худалдан авах, түрээслэх, түрээслүүлэх засварлан борлуулах зэрэг үйл ажиллагаанд зуучлах эрхтэй болсон байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Лэндмн бонд” Монголын хөрөнгийн биржээр амжилттай арилжаалагдлаа.

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 1-р ангилалд бүртгэлтэй “ЛэндМН ББСБ” /MSE: LEND/ ХК-ийн хувьцаагаар баталгаажсан 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нэг жилийн хугацаатай, жилийн 17.0 хувийн хүүтэй өрийн хэрэгсэл “Лэндмн бонд” нь 2020 оны 06-р сарын 15-ны өдрөөс 2020 оны 06-р сарын 19-ний өдөр хүртэл Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэйгээр арилжаалагдаж, нийт 5.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлээ.

Тус үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд нийт 528 иргэн, аж ахуйн нэгж оролцож, нийт 67,424 ширхэг буюу 6,742,400,000 төгрөгийн үнийн дүн бүхий нийт 541 худалдан авах захиалга ирүүлсэн нь үнэт цаас гаргагчийн санал болгосон хэмжээнээс 34.8%-аар давсан дүн юм.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн захиалгын хуваарилалтын төлөвлөгөөний дагуу 28.8 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй захиалгыг 100 хувь биелүүлж, түүнээс дээш давсан дүнтэй захиалгад үнэт цаасыг 58.8 хувиар хувь тэнцүүлэн хуваарилахаар боллоо.

СЗХ-ноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон гэж шийдвэр гаргасан үед хөрөнгө оруулагч нар өрийн хэрэгсэл авч чадаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийн буцаан авах эрх үүсэх юм.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Иргэдийн дундаж цалин нэмэгдсэн талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Энэ оны I улирлын байдлаар медиан цалин 917 мянга 189 төгрөг байсан бол улсын дундаж цалин нэг сая 259 мянга 700 төгрөг байна.

Дундаж цалинг 2015 оны IV улиралтай харьцуулахад 1.5 дахин нэмэгдсэн хэдий ч худалдан авах чадварыг илэрхийлэх бодит цалин 16.2%-аар өсжээ. Мөн нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин өмнөх оны мөн үеэс 8.8%-оор буюу 101.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Эх сурвалж: BloombergTV.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Оны эхний дөрвөн сард Монгол Улсад орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21.5%-аар буурч, 491.4 сая ам.доллар болсон байна.

Шууд хөрөнгө оруулалтын хэмжээ "Оюу Толгой" төслөөс ихээхэн хамааралтай байдаг ба уг төсөл нийт шууд хөрөнгө оруулалтын 90 гаруй хувийг нь дангаараа бүрдүүлдэг байна. "Turquoise Hill Resources" компани энэ онд "Оюу Толгой"-ий далд уурхайн бүтээн байгуулалтад 1.2-1.3 тэрбум ам.доллар зарцуулахаар төлөвлөж байсан ч цар тахлаас болж ажиллах хүчний хөдөлгөөн хязгаарлагдсаны улмаас 1-1.1 тэрбум ам.доллар болгон бууруулснаа тайлагнасан юм.

Эх сурвалж: BloombergTV.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Энэтхэг улс нүүрсний салбарт олон арван жилийн турш үргэлжилсэн Төрийн монополийг зогсоож, энэхүү салбарыг хувийн компаниудад нээлттэй болгож эхэллээ.

Тус улсын Нүүрсний яамны мэдээлснээр 41 уурхайн төслийг хамарсан эхний дуудлага худалдаа зохион байгуулагдаад байгаа юм байна. Нүүрс олборлох гэж буй компаниуд эхний 5-7 жилийн хугацаанд 4.3 тэрбум ам.долларын капиталын хөрөнгө оруулалт хийнэ гэж тооцоолжээ. Мөн тэдгээр хувийн компаниуд Энэтхэг улсын нүүрсний гарцыг жилийн 225 сая тонноор нэмэгдүүлнэ гэж үзэж байгаа юм байна.

Эх сурвалж: BloombergTV.mn



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.